

ТЕЛЕВИЗИЙН ЯРИЛЦЛАГА БА ТҮҮНИЙ ОНЦЛОГ

Г. Гучин-Ес*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн докторант.

Түлхүүр үг: телевиз, эфир, теле ярилцлага, ярилцагч, зураглаач, найруулагч, техникийн ажилтан, видео дүрс, монтаж буюу эвлүүлэг, эфирийн соёл.

Телевизийн ярилцлага бол хэвлэл, мэдээллийн бусад хэрэгслээр бэлтгэн нийтэлж, нэвтрүүлдэг ярилцлагуудаас ялгагдах өвөрмөц онцлогтой юм. Телевизийн ярилцлагад сэтгүүлч, ярилцагч хоёр гол үүрэгтэй оролцохоос гадна тэдний ард уг ярилцлагыг эфирт бэлдэж гаргадаг бүхэл бүтэн мэргэжлийн уран бүтээлчдийн баг, техникийн ажилчид байдаг.

Телевизийн ярилцлагыг шууд ба шууд бус гэсэн хоёр хэлбэрээр эфирт бэлтгэн цацдаг. Эдгээрийг ямар нэгэн асуудал хөндсөн сэдвээр эх сурвалжтай ярилцаж, түүний мөн чанар, хэн болохыг нь олон түмэнд ил гаргаж харуулах зорилго бүхий ток-шоу ярилцлага, эсвэл аливаа нэгэн үйл явдал, үзэгдлийн талаар эх сурвалжаас лавлаж, тодруулах замаар тухайн асуудал, сэдвийн өнцгийг барьсан товч тодорхой асуултанд мэдээлэл авах зорилгоор хийж буй мэдээлсэн ярилцлага гэж үндсэн хоёр төрөлд ангилна.¹

Гэхдээ ямар ч төрлөөр теле ярилцлага хийхэд сэтгүүлч өөрийн

баг болох зураглаач, найруулагч нартайгаа нягт хамтран ажиллах шаардлагатай. Учир нь сэтгүүлч тухайн ярилцлагыг хөтлөн удирдаж байгаа боловч, багийн гишүүддээ ярилцлагынхаа агуулга, ач холбогдлыг бүрэн тайлбарлаагүйгээс болж бичлэгийн явцад үл ойлголцох байдал үүсч болзошгүй юм. Энэ нь уг ярилцлагыг амжилттай болоход сөргөөр нөлөөлж мэднэ.

Иймд теле ярилцлага авахын өмнө сэтгүүлч, зураглаач, найруулагч нар хийх гэж буй ярилцлагынхаа сэдэв, агуулгын талаар тодорхой, нэгдсэн ойлголттой болсон байх шаардлагатай.

Телевизийн ярилцлага мэдээлсэн ба асуудал хөндсөн ток-шоу төрлөөр шууд болон шууд бус хэлбэрээр явагдаж болох юм. Тэгвэл ярилцлагын сэдэв, агуулга, ач холбогдлоос хамааран сэтгүүлч, ярилцагч хоёрын болон уг ярилцлагатай холбоотой дүрсээ хэрхэн авах, тэр дүрсээ ярилцлагын чухам ямар үед эфирт өгөхийг телевизийн найруулагч нар мэддэг. Уг дүрсдээ тохирсон хөгжим, дуу авианы асуудлыг дууны найруулагч, дууны операторууд найруулагчтай зөвлөлдсөний үндсэн дээр шийддэг. Энэ бүх уран бүтээлчдийн санаа сэтгэл нэгдэн ажиллаж байж телевизийн бүтээл

цогц байдлаараа хэрэглэгч, үзэгчдийн хэрэгцээг хангаж чадна.

Сэтгүүлчийн мэргэжлийн ур чадвар ярилцлагад голлох үүрэгтэй. Теле сэтгүүлч ярилцагчийнхаа сэтгэлийн хөдлөл, мэдрэмж болон тавигдаж буй асуултад хандаж байгаа реакцийг сайтар мэдэрч байх хэрэгтэй бөгөөд асуултынхаа хариултыг маш анхааралтай сонсож, үндсэн сэдвээсээ хазайсан тохиолдолд эелдэгээр залруулж байх ёстой. Учир нь эфирийн цагаа гамнаж, үзэгч олныхоо үнэт цагийг тухайн сэдэвт ямар ч ач холбогдолгүй сул яриагаар барах хэрэггүй².

Ер нь ярилцах сэдвийнхээ тухай ярилцагчаасаа илүү мэдлэгтэй, мэдээлэлтэй байж таны ярилцлага сонирхолтой болно. Ярилцагч нар ярьж, хэлж байгаа сэдвийнх нь талаар сайн ойлголттой сэтгүүлч нартай харилцахыг илүүд үздэг. Учир нь тэдний хооронд асуулт-хариулт гэсэн байцаалт бус, жинхэнэ мэдлэг боловсролтой, мэдээлэлтэй хоёр хүний хоорондох ухаалаг, дэлгэрэнгүй, ойлгомжтой яриа болдог. Ийм амьд ярилцлагыг телевиз үзэгч бүр амтархан үзнэ.

Хэрвээ та үнэн бодитой, тэнцвэртэй мэдээ, сурвалжлага хийдэг бол бусдаас ярилцлага хийх зөвшөөрөл авахад хялбар байх болно. Харин та сэтгүүлчийн ёс зүйгээ зөрчдөг, эрээ цээрээгүй, зарчимгүй сэтгүүлч гэсэн нэр зүүсэн бол хэн нэгнийг камерийнхаа өмнө авчирна гэж мөрөөдөхийн ч хэрэггүй.

Орчин цагийн сэтгүүл зүйн шаардлага бол аливаа нэг мэдэгдэл, мэдээллийн үнэн бодитой эсэхийг баталж, нотлох магадлал байгаа үгүйг олж илрүүлэх явдал юм. Олон түмэн бүхнийг мэдэх эрхтэй бөгөөд тэрч байтугай бусдын талаарх хамгийн нандин нууцыг ч гэсэн мэдэх ёстой мэт ойлголттой байдаг.

Иймээс телевизийн мэдээ, сурвалжлага, ярилцлагыг бэлдэж байгаа уран бүтээлчид мэргэжлийнхээ ёс зүй, хариуцлагыг сайн ухамсарлан ойлгосон байх ёстой.

Гэвч энэ бүхэнтэй зөрчилдөх явдал ялангуяа мэдээний ярилцлага авч байх үед ихэвчлэн тохилддог. Ямар нэгэн гэнэтийн осол аваар, эмгэнэлт үйл явдлын үед, түүнд өртсөн хүмүүс болон гэрчийн этгээдүүдээс ярилцлага авч сурвалжлах шаардлага зайлшгүй гардаг бөгөөд энэ

үед чухам юуг нь үзүүлж, эх сурвалжтаа ярилцлагадаа аль өнцгөөс харуулах нь тухайн сэтгүүлчийн шийдвэрээс хамаардаг. Сурвалжлах бүлэгт яваа хамт олны нэгдмэл санаа зорилго үүнд томоохон үүрэгтэй бөгөөд чухам энд л тухайн бүлгийг ахалж яваа сэтгүүлчийн мэргэжлийн ур чадвар, авьяас, нийгмийнхээ болон үзэгч олны сонирхлыг ойлгож мэддэг чанар илэрдэг.

"Сонирхолтой мэдээний хоиноос хөөцөлдөж яваа сэтгүүлч хүн заримдаа бусдын зовлон жаргал,

«

Ярилцагч нар ярьж, хэлж байгаа сэдвийнх нь талаар сайн ойлголттой сэтгүүлч нартай харилцахыг илүүд үздэг. Учир нь тэдний хооронд асуулт-хариулт гэсэн байцаалт бус, жинхэнэ мэдлэг боловсролтой, мэдээлэлтэй хоёр хүний хоорондох ухаалаг, дэлгэрэнгүй, ойлгомжтой яриа өрнөдөг. Ийм амьд ярилцлагыг телевиз үзэгч бүр амтархан үзнэ.

»

хувийн нууцыг ойлгох чадвараа алдах тохиолдол гарч болзошгүй. Иймд цаг ямагт үйл явдлыг телевиз үзэгчийн үзэл бодлын үүднээс олж харж, асуудлыг өргөн цар хүрээтэй, тэнцвэртэй талаас нь харуулах хэрэгтэй бөгөөд сэтгүүлчийн үүрэг зорилго бол бодит үнэнийг хувийн үзэл бодолгүйгээр мэдээллэх ёстой гэдгээ хэзээ ч мартаж болохгүй. Та хууль сахиулж, үнэн мөнийг тогтоогч биш"³.

Эмгэнэлт үйл явдалд өртөгсөд гашуудал зовлонгийнхоо талаар ярих хүсэлгүй, магадгүй, орь ганцаараа байхыг хүсэж байж мэдэх юм. Тэгвэл түүнийг нь хүндэтгэх хэрэгтэй. Гэтэл зарим нэгийг нь телевизийн камер, сэтгүүлчийн сониуч асуулт түр ч болтугай уй гашуудлаас нь сатааруулж мэдэх ба тэд ч гэсэн тохиолдсон гай зовлонгоо бусадтай хуваалцаж, сэтгэл дотроо нээх сонирхолтой байж болно. Энэ бүхнийг сэтгүүлч хүн маш гярхай мэдэрч байх хэрэгтэй. Үзэгчид бусдад тохиолдсон иймэрхүү гай зовлонг алсаас буюу дам маягаар өөр дотроо хуваалцаж байдгийг сана.

Олон өдөр, хоног нойр, хоолгүй ямар нэгэн сонирхолтой мэдээллийн хойноос хөөцөлдөж байж олж авсан дүрс гэдэг уран бүтээлч хүнд, ялангуяа зураглаачид хамгийн нандин зүйл боловч, учир шалтгааныг нь олж тогтоогоогүй тохиолдолд тэр дүрс бол юу ч биш байдаг. Гэтэл ярилцлагын гол ач холбогдлыг илэрхийлж чадах тэр агшны дүрсийг видео хальсандаа буулгаж чадаагүй бол тухайн ярилцлагын мөн чанар бас алдагдана гэсэн үг. Иймд теле сурвалжлагч, зураглаач хоёр нэг хүн мэт хамтарч ажиллах ёстой.

Эх сурвалжаас авч буй ярилцлагын сэдэв нь сонирхолтой байлаа ч гэсэн сэтгүүлч, ярилцагч хоёрын дүрсийг ээлжлэн харуулаад байх нь

тухайн теле ярилцлагын чанарын шаардлагад нийцэхгүй. Үүнийгээ телевизийн бусад техник, технологийг ашиглан сонирхолтой хэлбэрээр баяжуулж байх хэрэгтэй ба баяжуулж байгаа нь энэ гээд хэтэрхий эрээн, мяраан эффект, дуу авиагаар гоёж чимэж яавч таарахгүй.

Теле үзэгчид тухайн ярилцаж буй сэдвийн агуулага, үйл явдлыг өөрсдийн нүдээр харж, дотор нь орохыг байнга хүсэж байдаг бөгөөд үүнийгээ теле сэтгүүлчдээс ямагт шаардаж байдаг. Тэдэнд бүрэн гүйцэд ойлгуулж таниулахын тулд сайн сэтгүүлч хүн уг сэдэвтэйгээ холбоотой үйл явдал, мөн тус сэдэвтэй холбогдолтой ярилцагчийн дүрсүүдийг урьдчилаад авчихсан байх хэрэгтэй.

Эсвэл үйл явдал болж байгаа газар дээрээс ярилцлага авч байгаа бол уг сэдэвтэйгээ холбоотой бусад зүйлсийн дүрсийг ач холбогдолтой үгүйгээр нь ангилалгүй боллоцооныхоо хэрээр авч байх хэрэгтэй. Эдгээр материалууд таны ярилцлагыг улам сонирхолтой болгоод зогсохгүй, зарим эгзэгтэй үед буулгаж авсан видео дүрсүүд чинь ямар ч тайлбаргүйгээр бүх зүйлийг илэрхийлж болно.

Асуудал хөндсөн ярилцлагын явцад сэтгүүлч хүн ярилцагчийнхаа хэлсэн үг, мэдэгдлийг цорын ганц үнэн хэмээн хүлээн авахаас сэрэмжлэх, ялангуяа албаны эх сурвалжтай хийж байгаа ярилцлагын явцад "тэр ингэж хэлсэн юм чинь" гэсэн байдлаар хэлж, ярьж байгаад нь сэтгэл тайтгаран сууж болохгүй. Та үзэгч олны төлөөлөл гэдгээ ямагт санаж, энэ чиглэлээр хийсэн судалгаандаа тулгуурлан тэдний асууж мэдэх гэж хорхой нь хүрч байгаа тийм асуултуудыг ярилцагчдаа тавьж байх хэрэгтэй"⁴.

Ярилцлага өгч байгаа хүний юу хэлж, ярьж байгаа нь олон түмэнд сонирхолтой болохоос таны үзэл бодол, элдэв тайлбар, сул үгс үзэгчдийн тэвчээрийг барж байдгийг мартаж болохгүй. Гэхдээ энэ нь ярилцлагаа ярилцагчаараа удирдуулна өгнө гэсэн үг биш.

Теле ярилцлагыг хөтлөн явуулахад сэтгүүлч хүний мэргэжлийн ур чадвар, мэдлэг боловсрол, эфирийн соёл юу юунаас илүү чухал байдаг. Бичлэгийн ярилцлагын үед ямар нэгэн алдаа оноо, өө сэвээ мон-тажлан засварлах боломж байдаг бол шууд эфирт гарч байх үед сэтгүүлч хүнд тийм бололцоо үгүй.

Тэгээд ч үзэгч олон телевизийн дэлгэцээр гарч байгаа сэтгүүлч таны мэргэжлийн ур чадвар, мэдлэг боловсрол, хувийн соёлоор чинь телевизийнхнийг төдийгүй, орчин цагийнхаа нийгмийн шаардлагыг ойлгож, танаас үлгэр дууриалал авч байдгийг мартаж болохгүй.

Улс төрийн аль нэг сонгуулийн сурталчилгаа, нийгмийн өмнө тулгараад байгаа хурц маргаантай сэдвүүдээр ток-шоу төрлийн ярилцлагад эсрэг, тэсрэг байр суурь баримталдаг хоёр болон түүнээс олон эх сурвалжуудыг нэгэн зэрэг цэнхэр дэлгэцээр олон түмэнтэй уулзуулж, тэдний санаа бодлыг өөрсдийнх нь амнаас сонсох боломж гагцхүү телевизэд бий. Эдгээр ток-шоу ярилцлагуудыг шууд хэлбэрээр эфирт явуулах нь илүү бодитой, үр дүнтэй байдаг.

Түүнчлэн хэвлэл мэдээллийн бусад хэрэгслүүдийн ярилцлагаас ялгарах нэг онцлог нь орчин үеийн дэвшилтэд техник, технологийн туслалцаатайгаар дэлхийн өнцөг буланд байгаа мэдээллийн эх сурвалжуудыг нэг цаг, мөчид цэнхэр дэлгэцийн өмнө цуглуулан, тэдгээр хүмүүстэй нэгэн зэрэг шууд ярилц-

лага хийж, тэдний санаа бодлыг үзэгч түмэнтэй хуваалцуулж болдог. Энэ нь олон түмний мэдээллийн хэрэгсэлд хурцаар тавигдаж байгаа мэдээллийг шуурхай түгээх гэсэн зарчмыг хангаж байна гэсэн үг юм

Шууд ярилцлага хийх явцад тулгардаг нэг бэрхшээл нь ярилцагчийн хариултаас ургуулан асуулт тавих чадварыг тэр болгон, ялангуяа залуу сэтгүүлчид эзэмшиж чадаагүй байдаг оршдог. Та ямарч тохиолдол, үйл явдлын процесст оролцож байлаа гэсэн эх сурвалжтайгаа тухайн сэдвээр нь, нийгэм-улс төр, эдийн засаг, хууль эрх зүй ч бай хамаагүй, чөлөөтэй ярилцаж, үзэгчиддээ хэрэгтэй, тэдний сонирхож байгаа асуудлыг тэнцвэртэйгээр үзүүлж, харуулж чадах ёстой.

Түүнчлэн телевизийн шууд ярилцлагууд ямагт цаг хугацааны хязгаарлагдмал орчинд явагдаж байдаг тул та цагийн баримжаатай байж, найруулагчаас өгөх команд, дохионуудын дагуу бүх зүйлээ цагт нь багтааж хийх чаддаг байх хэрэгтэй. Энэ бол теле сэтгүүлч хүний эзэмшвэл зохих олон чухал чадварын нэг юм.

Хэдийгээр теле ярилцлагыг бэлтгэн явуулахад энэ мэтийн онцлогууд байдаг боловч сэтгүүлч хүнд тавигдах сэтгүүл зүйн бусад үндсэн зарчим, шаардлагууд теле сэтгүүлчид мөн адил тавигдах гарцаагүй юм.

Ишлэл

¹ Ю р о в с к и й А. Я. Основы телевизионной журналистики. С. 68-88.

² Р е н д а л л Д. 1996. Универсальный журналист. Алтаты. С. 77, 81.

³ М е н ч е р М. 2002. Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс. Х. 25-37.

⁴ Мөн тэнд. Х. 17-33.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Рендалл Д. 1996. Универсальный журналист. Алтаты.
2. Менчер М. 2002. Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс.
3. Андерсен Х. нар. 1998. Нийтлэл нэвтрүүлгийг яаж бэлтгэх вэ. УБ.
4. Константинов А. 2001. Журналистское расследование. М.

Резюме

В этой статье автор рассказывает об особенностях телевизионного интервью. Автор уделяет немало внимания качествам,

которыми должен обладать тележурналист во время интервью с источником информации. Телевизионное интервью в своём развитии оставило позади газетную разновидность жанра, поскольку обогатилось весьма существенным качеством – зрелищностью. В силу аудиовизуального характера телевизионной коммуникации источником информации становится уже не только звучащая речь, ее ритмика, ее интонационная, эмоциональная окраска, но и мимика, жест, собственно поведение собеседников. Именно зрелищностью объясняется особая достоверность и, как следствие, широкое распространение жанра интервью в телепрограммах.